

## **“Зохиолчийн цаг”**

Бичсэн Ariya

2018 оны 3-р сарын 26, Даваа гариг, 18:30 - Сvvлд шинэчлэгдсэн 2018 оны 3-р сарын 28, Лхагва гариг,  
11:12

---



**Цэндийн Дамдинсүрэн  
(1908-1986)**

**Их эрдэмтэн, нэрт зохиолчийн мэндэлсний 110 жилийн ойд**

Энэ онд их эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсврэнгийн мэндэлсний 110 жилийн ой тохиож байгаа билээ.

Ц.Дамдинсврэн нь 1908 онд Дорнод аймгийн Матад суманд жирийн малчны гэрт торжээ.

### **НЭГ. Ц. Дамдинсврэн бол нэрт зохиолч юм.**

Монголын шинэ veийн уран зохиолыг vндэслэгчдийн нэг Цэндийн Дамдинсврэн “Гологдсон хvvхэн”, “Багш шавь хоёр”, “Хоёр цагаан юм”, “Хоёулаа миний хvv”, “Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл”, “Чемодантай юм”, “Бух Гомбо”, “Солийг сольсон нь” зэрэг vргэлжилсэн vгийн зохиол, “Монгол улсын торийн дуулал”, “Зугаацахаар мордсон нь”, “Хоёр настай Po”, “Буурал ээж минь”, “Монгол нутаг” зэрэг олон сайхан бvтээлээрээ Монголын шинэ veийн уран зохиолын урын санг баяжуулаад зогсохгvй монхийн сайхан бvтээлээрээ ve veийн хvvхэд багачуудын оюуныг тэтгэж, хайрыг булаасан алдар гавьяатай бичгийн х хvн, нэрт зохиолч юм. Ийм учраас Монгол улсын торийн шагналыг гурван удаа хvртэж “Ардын уран зохиол” гэдэг эрхэм цолыг анх удаа хvртсэн эрхэм хvн билээ. Юм.

### **ХОЁР. Ц. Дамдинсврэн бол нэрт эрдэмтэн**

Ц. Дамдинсврэн гуай амьдралынхаа ихэнх хэсгийг эрдэм судлалын ажилд зориулжээ. Ялангуяа Монголын эртний уран зохиолыг судалж дэлгэрvvлэхэд vнэлж баршгvй хувь нэмрээ оруулсан юм. Монголын нууц товчоог судалж, эртний монгол хэлнээс орчин цагийн монгол хэлэнд буулгасан нь оноогийн бидний ширээний ном болсон юм. Монголын эртний уран зохиолын 3 боть, “Монгол Орос толь”, “Гэсэр” туужийн судалгаа, оноогийн бидний бичиж байгаа кирилл vсгийн цагаан толгой, тvvний зов бичих дvрэм гээд энэ хvний эрдэм судлалын нор их ходолморийг vгээр хэлэхийн аргагvй. Ц. Дамдинсврэн бол Монголын шинжлэх ухааны хогжилд хосгvй гавьяатай аугаа их эрдэмтэн хvн юм.

### **ГУРАВ. Ц. Дамдинсврэн бол нэрт орчуулагч юм.**

Монголын уншигчдыг дэлхийн утга зохиолтой танилцуулахад vнэхээр их гавъяа байгуулсан хvн юм. Тэр А.С. Пушкины “Алтан загасны vлгэр”, “Yвл”, Овлийн овгон”, “Онхрvvшхэн” зэрэг шилдэг бvтээлээс гадна Лермонтов, Шиллер, Ян Неруда зэрэг дэлхийн уран vгийн дархчуудын гайхамшигтай бvтээлvvдийг Монголынхоо уншигчиддаа танилцуулсан авьяаслаг нэрт орчуулагч хvн юм.

Эрхэм уншигч та бvхэндээ их зохиолчийн алдарт “ГОЛОГ ДСОН ХYYХЭН” туужийн хамгийн сонирхолтой хэсэг буюу туужийн тайлал болох тогсголийн “Баярт учрал” хэсгээс толилуулж байна.

... Цэрэн хvvхэн мон энэ оны намар ходоо албаар явах болж баярлан мордож баруун зvг явахад долоо найм хоноод салбар ортоогоор дамжин явж, нэг хошууны тамгын газар хvрлээ. Залуучуудын vvрийн хурал ба энгийн ардын хурал зэргийг зарлаж, заавар бvхий ажлуудыг гvйцэтгэх зуураа, Долингар эцэгтэйгээ тэнд учирсан ажээ. Долингар Цэрэн хоёр бие биеэ танихгvй богоод Цэрэн миний эцэг урьд Хvрээнд vxсэн гэж санана. Долингар бяцхан охин гэргийгээ тэр зvvн аймагт эрээд эс олсон тул энд учирна гэж огт санах аргагvй. Эцэг хvvхэн хоёр нvvр учирсан болов ч бие биеэ таниагvй билээ. Тэр одор Цэрэн буцахыг завдсан боловч ямар нэгэн хэрэг эс бvтсэн учир даиннэг онжих болов. Тусгаар гэрт сууж байсан тул, хуучин галчид шалтаг тохиолдсон учир оронд нэг хvн

## “Зохиолчийн цаг”

Бичсэн Агиа

2018 оны 3-р сарын 26, Даваа гариг, 18:30 - Сvvлд шинэчлэгдсэн 2018 оны 3-р сарын 28, Лхагва гариг, 11:12

---

суулгахад Долингар овгон, хvvхний хоол цайг бэлтгэн суух зуураа хэрэгтэй хэрэггvi юмыг ярьсаар, оорийн явдлыг ярьж, муу овгон чинь зовлон vзсэн толгойдоо гэж зовж зvдэрч явсныгаа тоочин ярихад Цэрэн хvvхэн санаа авч, эцгийн явдлыг урьд эхээсээ сонссонтой зарим vг яв цав нийлж, овгоний хуучин хошуу хvртэл тохирохоор харилцан идэвхлэн асуулцсаар хvvхэн урьдаар эцгээ таньж, Долингар дараагаар хvvхнээ таньж миний хvvхэн гэж хашхиран хvзvvдэн авлаа. Тов газраас томилогдон яваа залуу хvvхнийг ходсон дээлтэй ядуу овгон тэврээд, учир зvггvi vвсэхэд ойрын хvmvвс цуглаж, мунасан овгон мунхаглаж, тэнэсэн овгон тэнэглэж, албаны хvнийг самардлаа гэж ая зvйг олж салгахыг оролдов.

50-иад нас хvртэл, насан туршаар зовсон Долингарын хоёрдугаар баяр нь энэ билээ. Долингар Мятагийг мэнд сууж байгаа гэхийг сонсож, эдvгээ хvvхэнтэйгээ уулзсанаар vl барам Мятагтай бас уулзаж болно гэж санаж, богс ондолзох болов ч, яахин явж хvрэхийг мэдэхгvi явган явахаас оор аргагvi болов уу гэхэд Цэрэн хамт явъя гэж зовшооролцож, маргааш явах болоод Долингар гэртээ харьж Батын эцэг хэдийн vхсэн тул тvvний эмгэн Бат хоёрт учир явдлаа сайхан хэлэхэд, тэр хоёрын сэтгэл бас ходолж, гурвуулаа тарган мах чанаж, сайхан цай уугаад бие биедээ салах ёс хийж дараа баяртай учрахын ероолийг тавьж салаад, Долингар явж тамгын газар ирээд унтах гэтэл ер нойр хvрэхгvi тул шоно их урт мэт санагдаж, тийчэгнэн хэвтэж тэсэлгvi баярлах тул заримдаа инээд нь хvрэх мэт болов санаа алдаж, нvднээс нь нулимс дусална. Хvvхэн залуу хvн тул сэрэхгvi унтахад, овгон хvvхнээс асуумаар, хэлмээр олон зvйл бодогдож, vнэхээр оглоо болохыг маш их хvсэн хvlээж энэ баярлаж байгаа нэг шоно нь зовж онгорvvлсэн тавин жилээс урт мэт санагдана.